

## ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2021 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр  
Тендер шалгаруулалтын нэр: **“ДЦС4/2021-АУ/36 дугаартай Утааны яндангийн засвар дээрээсээ 50м”**

Тендер шалгаруулалтын дугаар: **ДЦС-4/2021-АУ/36**

**“ДЦС-4” ТӨХК** нь эрх бүхий тендерт оролцогчдоос **“Утааны яндангийн засвар дээрээсээ 50м”**-ыг хийж гүйцэтгэх тухай цахим тендер ирүүлэхийг урьж байна.

Энэхүү тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг үнэ төлбөргүйгээр татан авна уу.

Тендерт оролцогч нь тендер илгээхийн өмнө 100.000 /зуун мянга/ төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байх ёстой.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 30 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Борлуулалтын хэмжээ: Сүүлийн 2 жилийн жил тус бүрийн борлуулалтын орлого нь тендерт санал болгож буй үнийн дүнгээс багагүй байна. 2019, 2020 он тус бүрээр
2. Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: Тендерт санал болгож буй үнийн дүнгээс багагүй байна.
3. Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: сүүлийн 2 жил. 2019, 2020 он
4. Сүүлийн 2 жилд хэрэгжүүлсэн ижил төстэй гэрээгээр гүйцэтгэсэн ажил: Жил тус бүрийн дүн нь тендерт санал болгосон үнийн дүнгээс багагүй байх /2019, 2020 он/
5. Тусгай зөвшөөрөл шаардлагатай эсэх: Тухайн ажил үүргийг гүйцэтгэх тусгай зөвшөөрөлтэй байх /барилгын тусгай зөвшөөрөл 2.1.1, 2.1.2, 3.2, 4.2, 5.2/.
6. Тендерийн хамт төсөвт өртгийн үнийн дүнгийн 2%-тай тэнцүү дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Засгийн газрын бондоор ирүүлсэн тендерийн баталгааг хүлээн зөвшөөрнө.

Хүчинтэй байх хугацаа: 2021 оны 07 дугаар сарын 26-ны өдөр дуустал

Тендерийг 2021 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн 10.00 цагаас өмнө цахим системээр илгээх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2021 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн 10 цаг 30 минутад нээнэ.


Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхгүй, Дотоодын давуу эрх тооцохгүй.

Сонирхсон этгээд бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 20 дугаар хороо, Эрчим хүчний гудамж,  
“ДЦС-4”ТӨХК-ийн Захиргааны байр, 3 дугаар давхар, 310 тоот өрөө Худалдан авах  
ажиллагааны хэлтэс Утас 7018-1309, 7000-1357, 7017-1357, Факс 7018-1309 7000-1357**

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

ХААХ-ЫН ДАРГА



Ү.ТӨМӨРХУЯГ

В.ЛХАГВАДОРЖ